



“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН
ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын
29- ны өдөр

Дугаар 01.22

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын ирц болон хурлыг хүчин
төгөлдөрт тооцох тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 67 дугаар зүйлийн 67.3.1-д заасныг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 2206112 саналын эрх буюу 64,3% нь өөрийн биеэр,
681828 саналын эрх буюу 19.6%-нь санал хураах хуудсаар нийт 2887940 саналын эрх бүхий хувьцаа
эзэмшигчид оролцсоноор хурлын ирц 83%-д хүрснийг хурлын дарга, болон хувьцаа эзэмшигчдэд
мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан хүчинтэй ирцид хүрсэн тул
хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Д.МӨНХБААТАР

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮД:

Б.МӨНХТУУЛ

Т.МӨНГӨНЦӨӨЖ

Ч.ЭНХЦЭЦЭГ



“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН
ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын
29- ны өдөр

Дугаар 02.22

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
тооллогын дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийн 63.4, 63.5 дугаар заалт, 72 дугаар зүйлийг удирдлага болгон “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал хураах хуудсаар өгсөн нууц санал хураалтад явуулсан тооллогын дүнгийн тухай тооллогын комиссын Т-01.22 тоот тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд орсон хувьцаа эзэмшигчдийн 2887936 санал буюу 99.99%-ийн саналаар ТУЗ-өөс компанийн Үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг батлах,

2. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн кумулятив 2887769 санал буюу 11.11%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, кумулятив 2887757 санал буюу 11.11%-ийн саналаар Б.Ёндонжамцыг, кумулятив 2887664 буюу 11.11%-ийн саналаар Д.Мөнхбатыг, кумулятив 2887670 буюу 11.11%-ийн саналаар С.Алимааг, кумулятив 2887736 санал буюу 11.11%-ийн саналаар Х.Ханияаг, кумулятив 2887664 санал буюу 11.11%-ийн саналаар Х.Мөнхтуяаг тус тус ТУЗ-ийн энгийн гишүүнээр,

Кумулятив 2887664 санал буюу 11.11%-ийн саналаар Б.Аюушийг, кумулятив 2887664 санал буюу 11.11%-ийн саналаар Э.Бямбажавыг, кумулятив 2887664 санал буюу 11.11%-ийн саналаар Б.Болдыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус сонгох,

3. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2887936 санал буюу 99.99%-ийн саналаар ТУЗ-ийн 2022 оны 2 сарын 18-ны өдрийн 12/21 тоот тогтоолоор баталсан 2021 оны ногдол ашгийг цэвэр ашгийн 25%-иар нэгж хувьцаанд 39.90 төгрөг (гучин есөн төгрөг 90 мөнгө)-өөр буюу 138822.6 мянган төгрөг (нэг зуун гучин найман сая найман зуун хорин хоёр мянга зургаан зуун) –ийг хуваарилахаар шийдвэрлэсэн шийдвэрийг дэмжсэн,

4. Хувьцаа эзэмшигчдийн 2887936 санал буюу 99.99%-ийн саналаар Компанийн удирдлагын 2022 оны зардлын төсөвийг зардлын төсвийг 55510.0 мян.₮ (Тавин таван сая таван зуун арван мянган)- өөр батлах,

5. Хуралд оролцогчдын саналын хуудсаар өгсөн саналд явуулсан тооллогын дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулахыг Тооллогын комиссын дарга (Д.Мөнхбаатар)-д даалгасугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Д.МӨНХБААТАР

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮД:

Б.МӨНХТУУЛ

Т.МӨНГӨНЦООЖ

Ч.ЭНХЦЭЦЭГ



“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын
29- ны өдөр

Дугаар 01.22

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9-дэх хэсэг, “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.22 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.22 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 1, 2 дугаарт заасныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2887936 санал буюу 99.99 %-ийн саналаар, Компанийн 2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ -өөс өгсөн дүгнэлтийг батласугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, компанийн өртөг зардлыг бууруулах, ашгийг нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөгөөр тавьсан зорилтыг биелүүлэх бодитой арга хэмжээг хэрэгжүүлэн, ТУЗ-д сар бүр ажлаа дүгнүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д үүрэг болгосугай.

Хурлын дарга

Д.Мөнхбат

Тооллогын комиссын дарга

Д.Мөнхбаатар



**“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 04 дүгээр сарын
29-ны өдөр

Дугаар 02.22

Улаанбаатар хот

Компанийн удирдлагыг сонгож,
батлах тухай.

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дугаар заалт, “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.22 тоот тогтоол, ХЭХ-ын Т-01/22 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3 дугаарт заасныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн кумулятив
2887769 санал буюу 11.11 %-ийн саналаар С.Мөнхжаргалыг,
2887757 санал буюу 11.11 %-ийн саналаар Б.Ёндонжамцыг,
2887664 санал буюу 11.11 %-ийн саналаар Д.Мөнхбатыг,
2887670 санал буюу 11.11 %-ийн саналаар С.Алимааг,
2887736 санал буюу 11.11 %-ийн саналаар Х.Ханияаг,
2887664 санал буюу 11.44 %-ийн саналаар Х.Мөнхтуяаг тус тус ТУЗ-ийн энгийн гишүүнээр,
2887664 санал буюу 11.11 %-ийн саналаар Б.Аюушийг,
2887664 санал буюу 11.11 %-ийн саналаар Э.Бямбажавыг,
2887664 санал буюу 11.11 %-ийн саналаар Б.Болдыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус сонгосныг баталсугай.

2. “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааг удирдлага хяналтаар хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл (С.Мөнхжаргал)- д зөвшөөрсүгэй.

Хурлын дарга



Д.Мөнхбат

Тооллогын комиссын дарга

Д.Мөнхбаатар



“АРИГ ГАЛ” ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр сарын
29- ны өдөр

Дугаар 03.22

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах
тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйл, Компанийн ногдол ашгийн бодлогын тухай журам, ТУЗ-ийн 2022-- оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 12.20 тоот тогтоолоор гаргасан шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.21 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.21 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 4 дүгээрт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2887936 санал буюу 99.99 %-ийн саналаар 2021 оны ногдол ашгийг цэвэр ашгийн 25%-иар нэгж хувьцаанд 39.90 төгрөг (гучин есөн төгрөг 90 мөнгө)-өөр тогтоосугай.

2. Ногдол ашигт зарцуулагдах 138822.6 мянган төгрөг (нэг зуун гучин найман сая найман зуун хорин хоёр мянга зургаан зуун) –ийг компанийн ашгаас гаргахыг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д зөвшөөрсүгэй.

3. Компанийн мөнгөн гүйлгээний боломжтой үед зохицуулан, 2022 оны 6 дугаар сард багтаан Ногдол ашгийг нийтэд зарлан, тараах ажлыг зохион байгуулан гүйцэтгэхийг гүйцэтгэх захирал /Х.Хания/-д даалгасугай

Хурлын дарга

Д.Мөнхбат

Тооллогын комиссын дарга

Д.Мөнхбаатар



**“АРИГ ГАЛ “ ХК
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 04 дүгээр сарын
29- ны өдөр

Дугаар 04.22

Улаанбаатар хот

Компанийн удирдлагын зардлыг
батлах тухай.

“Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.13 хэсэг, хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01.21 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын Т-01.22 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 4 дэхь заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн удирдлагын зардлын 2022 оны төсвийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 2887936 санал буюу 99.99 %-ийн саналаар 55510.0 мян.₮ (Тавин таван сая таван зуун арван мянган)- өөр баталсугай.

2. Батлагдсан төсөвт багтаан компанийн удирдлагын зардлыг санхүүжүүлэхийг гүйцэтгэх захирал (Х.Хания)-д, зардлын зарцуулалтын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга (С.Мөнхжаргал) –д тус тус даалгасугай.

Хурлын дарга

Д.Мөнхбат

Тооллогын комиссын дарга

Д.Мөнхбаатар